



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 04 өдөр

Дугаар A/128

Батноров сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 тоот тушаалын хавсралт (Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам)-ийн 3.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдэх “Шинэ бага сургуулийн урлаг заалны сандал шинээр авах” ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээнд заагдсан хугацаанд тус ажлыг 100% гүйцэтгүүлэн хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Бямбацогт (Засаг даргын Орлогч)

Нарийн бичгийн дарга:

Г.Цолмонтуяа (Соёл, сангийн нягтлан

бодогч)

Гишүүд:

Г.Цэцэгсүрэн (ЕБС-ийн Захирал)

З.Хөхмөрөн (ЕБС-ийн Нягтлан)

С.Бямба (ЕБС-ийн Нярав)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, явцын чанар, ажлын тоо хэмжээ, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд захиалагч байгууллагыг бүрэн төлөөлж хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмолжуулан удирдлагыг мэдээллээр хангаж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, явцын дүгнэлт, гүйцэтгэлд акт үйлдэн тус ажлыг бүрэн хүлээн авах ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ОТГОНБАЯР

23530033